**МОНГОЛ УЛС**
**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 12 сарын 20 өдөр Дугаар А/454 Мөрөн сум

Барилгын засварын ажил хүлээж
авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2. 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэгийн барилгын засварын ажил хүлээж авах ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)

Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Д.Мягмарсүрэн (Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Барилга техник хяналтын улсын байцаагч)

Л.Бямбасүрэн (Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, хошууч )

Э.Сумъяасүрэн ("Хөвсгөл барилга захилагчийн хяналтын төв" ОНӨААТҮГазрын хяналтын инженер)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:
Г.Баасанжав ("БАББ" ХХК-ийн Захирал )

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:
Н.Даваахүү ("Хөвсгөл мичид" ХХК-ийн Захирал )

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Г.Оюунжаргал ( Аймгийн Нэгдсэн эмнэлэгийн захирал)

Л.Насанжаргал ( Аймгийн Нэгдсэн эмнэлэгийн Санхүү эдийн засаг, аж ахуйн салбарын дарга )

671 011733

Комиссын нарийн бичгийн дарга:
Д.Нямбат (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Барилгын засварын ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилгын засварын ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Д.Нямбат) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар ( Б.Мөнгөн-Эрдэнэ )-т үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН